

**УРГАМАЛ ХАМГААЛАЛЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН, БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ 2019-2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр

Багануур дүүрэг

№	Гүйцэтгэх ажлууд	Биелэлт	Дүгнэлт
1.	Тус байгууллагатай уулзалт танилцуулга зохион байгуулж, хамтын ажиллагааны чиглэлийг тогтоон гэрээ байгуулах	04.11-ний өдөр ШАУИС-ийн удирдлагатай Санамж бичиг байгуулж төлөвлөгөө баталсан.	Хамтын ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан 2020 онд үргэлжлүүлнэ.
2.	Эрдэм шинжилгээний байгууллага, тариаланчид, үйлдвэрлэгчид, иргэдийг хамруулсан “Эмийн ургамал, жимс, жимсгэнэ тариалах нь” сэдэвт сургалт, зөвлөгөөн, зохион байгуулахад оролцох	Багануурт биотехнологийг эрчимтэй хөгжүүлэх суурь бэлтгэлийг хангах, дүүргийг Эко-Хот болгон хөгжүүлэх санаачлагын хүрээнд “Эмийн ургамал, жимс жимсгэнэ тариалах нь” сэдэвт уулзалт зөвлөгөөнийг ХААИС, УХЭШХ, ШАУИС, Монхимо ХХК-тай хамтран дүүрэгтээ 06.21-ны өдөр зохион байгуулж, 40 гаруй хүн оролцож, 8 илтгэлийг тавьж, хэлэлцүүлэн санал зөвлөмжүүдийг өгөв. Тус зөвлөгөөнд тавигдсан илтгэлүүдийн сэдвийн жагсаалтыг хавсаргав.	Ирэх оноос иргэдийн хүсэлтийг үндэслэн эмийн болон ховор ургамал, жимс, жимсгэнэ, мод, бут тариалах үзүүлэх сургалтын нээлттэй өдөрлөгийг дүүргийн хэмжээнд зохион байгуулах арга хэмжээ авна.
3.	Ховор ургамлыг тариалах чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллага, тариаланчид, үйлдвэрлэгчид, иргэдийн оролцоотой нээлттэй өдөрлөгийг зохион байгуулахад оролцох	-	2020 онд хамтран зохион байгуулна.
4.	Плантацид тариалахад тохиромжтой ховор эмийн ургамлуудын судалгаа явуулж, гербари цуглуулга хийхэд дэмжлэг үзүүлэх	УХЭШХ-ээс нэг ургамлын гербари бэлэглэсэн нь манай цуглуулгын эхлэл болсон.	Паркийн хувьд плантацид тариалахад тохиромжтой ховор эмийн ургамлуудын гербари цуглуулга хийхэд эрдэмтэн судлаачдын зөвлөмж, зөвлөгөөг авна. Парк гербарийн булантай болох зорилготой.
5.	Байгууллагуудын хамтарсан “Бүтээлч-Аялал” зохион байгуулах Үүнд: → Дарханы эрдэм шинжилгээний хүрээлэн → Хэрлэнбаян-Улаан болон Хөх нуурын биостанцын ховор ургамлын тариалан	06.21-22-ны өдрүүдэд зөвлөгөөнд оролцсон эрдэмтэн, судлаачидтай хамтран Хэрлэнбаян-Улаан болон Хөх нуурын биостанцын ховор ургамлын плантацитай танилцаж, туршлага судлаж, 18 хүн оролцсон бүтээлч аялалыг зохион байгуулав.	ШАУИС, ХААИС-ийн багш судлаачид өөрийн плантацийн үйл ажиллагаатай танилцуулсан маш үр дүнтэй, туршлага хуримтлуулсан бүтээлч аялал боллоо. Хэрлэнбаян-Улааны плантацийн газар орон нь Баганууртай ижил төстэй байгаа нь паркад плантаци байгуулахад боломжтой харагдлаа.

		Плантаци байгуулсан газар орон, цаг уур, хөрсний байдлыг үзэж, плантацийн ерөнхий зохион байгуулалттай танилцав.	Танай сургуулийн зүгээс өөрийн Борнуурын плантаци үзүүлэх сайхан санал тавьсан ч манайд архивын улсын үзлэг ирэх хугацаа давхцаад чадаагүй тул 2020 онд зохион байгуулмаар байна.
--	--	--	---

ХЯНАСАН:
 БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
 ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

A handwritten signature in black ink, appearing to be "D. Altangerel".

Д. АЛТАНГЭРЭЛ

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
 КЛАСТЕР ИНЖЕНЕР

A handwritten signature in black ink, appearing to be "E. Enkhzaya".

Э. ЭНХЗАЯА